

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 32<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### **“32<sup>1</sup> дүгээр зүйл. Төсвийн төслийг дахин өргөн мэдүүлж, батлах**

32<sup>1</sup>.1. Улсын Их Хурал улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол Засгийн газар холбогдох төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

32<sup>1</sup>.2. Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийн танилцуулга, тооцоо, судалгааг энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсөвт үндэслэн боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тусгасан байна.

32<sup>1</sup>.3. Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу төсвийн төслийг өргөн мэдүүлэхдээ энэ хуулийн 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй.

32<sup>1</sup>.4. Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасны дагуу өргөн мэдүүлэх төсвийн төсөлд энэ хуулийн 8.4, 8.5 дахь хэсэг, 28<sup>1</sup> дүгээр зүйл хамаарахгүй.

32<sup>1</sup>.5. Улсын Их Хурал энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан төсвийн төслийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батална.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг